

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 1 ДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 15 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Ганболдын Нандинжаргалд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

		<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд Дамдинсүрэнгийн Лхамсүрэнд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай</p>	<p>"Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар"-ыг сайжруулан боловсруулж, дараагийн хурлаар хэлэлцэх тул хойшлуулахаар шийдвэрлэв.</p>
3	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2013 оны А/1677 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь Салбар зөвлөлийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Буянхүүгийн Батдэлгэрийг томилох.</p> <p>2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 6 дугаарт заасан "...Даваажавын Мөнх-Эрдэнэ" гэснийг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Б.Батдэлгэрт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны</p>

		зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
4	Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2014 оны 01 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн мэргэжилтэн Гэрэлбатын Мөнхгэрэлийг томилох.</p> <p>2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 17 дугаарт заасан “...Моломын Отгонбат” гэснийг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Мөнхгэрэлд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ